## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.06.20

| д/д | Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Авилгын эсрэг хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | Авилгын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх<br>-Үр дүнг тооцож нотломжийг хавсаргах | Дүүргийн соёлын ордонд болон явуулын нэг цэгийн үйлчилгээгээр ажлаа танилцуулах өдрийг зохион байгуулж, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар мэдээлэл авч байгаа иргэдэд авилгын эсрэг хуулийг давхар сурталчлан авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнд өртөхгүй байх, авилгатай холбоотой мэдээ мэдээллийг 110 дугаарын утсанд шударгаар мэдэгдэх үүрэгтэй зэрэг ойлголтыг тайлбарлан мэдээлэл хүргэж ажиллаж байна.<br>Тус газраар үйлчилгээ авч байгаа иргэдэд авилгын тухай, албан хаагчдад авилгаас урьдчилан сэргийлэх, түүнд өртөхгүй байх сурталчилгааг тогтмол хийж ажилладаг. |
| 2 | Авилгын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | Хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж буй байгууллагуудын гэрээнд авилгаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | -Байгуулсан гэрээнүүдэд авилгаас ангид байх<br>-Авилгыг мэдээлэх үүргийг тусгасан байх<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулсан байх<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх<br>-Нотломжийг хавсаргасан байх | Тус газар нь ус, дулаан хангамж, цахилгаан, байр орон сууц, хог тээвэрлэлттэй холбоотой төлбөр хураамжийн гэрээг холбогдох байгууллагуудтай хийдэг бөгөөд энэ нь авилга үүсэх шалтгаант заалт тусгагдахааргүй байна. Худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ байгуулагдаагүй.<br>НДЕГ-ын даргын Хаан банктай 2024.02.01-ний НД-07/24-222 тоот, Төрийн банктай 2024.02.01-ний НД-06/24-01б/276 тоот хамтран ажиллах гэрээг заалт бүрээр үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэрээг бүтэн жилээр дүгнэхээр гэрээнд тусгагдсан байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Байгууллагын удирдлагын авилгатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 3.1 Авилгатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны ХЭГ/595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах | -Үйл ажиллагаандаа чиглэлийг мөрдөж ажиллах | Зөрчилтэй томилогдсон албан хаагч байхгүй.<br>Газрын хэмжээнд 2 ажлын байрны сул орон тоо гарсан бөгөөд дүүргийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллээр болон ХХҮХ-т ТАЗ-ын 25 дугаар тогтоолын дагуу сэлгэн ажиллах зарыг хүргүүлсэн. Сул орон тоо нөхөгдөөгүй тул төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах шалгалтын зарыг НДЕГ-т 2024.06.21-нд хүргүүлсэн. |
| | | 3.2 Газрын хэмжээнд авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажлыг санаачлан хийх талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | -Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх<br>-Тайлагнасан байх | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр зорилтын 4.1.7 дахь заалтад тусгасан бөгөөд 2024.06.20-нд хагас жилийн биелэлтийг гаргаж ажилласан.<br>Авилга, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд Төрийн албаны зөвлөл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мөн байгууллагын ЭБАТ албан хаагчдад дотооддоо 1 удаа мэдээ, мэдээлэл өгч ажилласан. |
| | | 3.3 Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх<br>-Тайлагнасан байх | Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 2 заалтыг тусгасан бөгөөд албан хаагчид хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. |
| | | 3.4 Нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр зурагт хуудас түгээх | -Зурагт хуудас хэвлүүлж түгээсэн байх | Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд авилгааас урьдчилан сэргийлэх гарын авлагыг түгээж, хагас жилийн байдлаар ажлаа танилцуулах өдөрлөгөөр 78 иргэнд, тус газраар үйлчлүүлсэн 126 иргэнд гарын авлага тарааж ажилласан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.5 Байгууллагын авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх хийгдсэн мэдээллийг дүүргийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээх ажлыг зохион байгуулах | -Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээсэн байх | Авилгатай тэмцэх газар болон Нийгмийн даатгалын ерөнхий газраас авилгалын эсрэг тавигдсан постерыг байгууллагын фэйсбүүк хуудас, мөн албан хаагчид өөрийн фэйсбүүк хуудсаар дамжуулан шейрлэж байна. |
| | | 3.6 Дотоод нөөц бололцоог ашиглан албан хаагчдад сургалт зохион байгуулах | -Албан хаагчдыг авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх<br>-Тайлант нотломжийг хавсаргах | Авилга, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд Төрийн албаны зөвлөл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мөн байгууллагын ЭБАТ албан хаагчдад дотооддоо 1 удаа мэдээ, мэдээлэл өгч ажилласан. |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Б.УДВАЛ

ХЯНАСАН:
ДАРГА Б.БАЯРТУЯА

5289211
9024010422
AMT05736